**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
Энхтайваны өргөн чөлөө-57, 13 дугаар хороо,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13330
Утас/Факс: (976-51) 26 63 59
Цахим хуудас: www.bzd.ub.gov.mn

2025.12.23 № 02/3014

танай ____________ -ны № ____________ -т

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВД

Тус дүүргийн 6 дугаар хорооны иргэн Аймгийн мэргэн, спортын мастер А.Дагзмаа нь Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан тул шилдэг өвлөн уламжлагч шагналд нэр дэвшүүлж саналыг хүргүүлэв.

Хавсралт 42 хуудастай.

Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газар
Удирдлага
Засаг даргын Тамгын газрын даргын үүрэг гүйцэтгэгч
Дагмид Бат-Өлзий
2025.12.23 16:43

**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН**
**6 ДУГААР ХОРООНЫ ЗАСАГ ДАРГА**

Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж, 6 дугаар хороо,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13373
Утас: (976-11) 45 02 15
Цахим хуудас: www.bzd.ub.gov.mn

2025.12.12 № 163

танай ____________-ны №____________-т

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГА Г.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

Тус хорооны иргэн Алтангэрэлийн Дагзмааг соёлын биет бус өвийг сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсныг үнэлж өвлөн уламжлагчийн шагналд тодорхойлов.

Б.ЭНХБААТАР

СТС4468 9095489

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
6 ДУГААР ХОРООНЫ ЗАСАГ ДАРГА

# ТОДОРХОЙЛОЛТ

Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж, 6 дугаар хороо,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13373
Утас: (976-11) 45 02 15
Цахим хуудас: www.bzd.ub.gov.mn

2025. 12. 12 № 417

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВД

Алтангэрэлийн Дагзмаа (РД:РЭ51110901) нь тус хорооны 64-26 тоотод оршин сууж байгаа болно.

СТС4468 9095489

Б.ЭНХБААТАР

1325041873

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХАРВААЧДЫН ХОЛБОО
MONGOLIAN NATIONAL ARCHERY FEDERATION

Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг, 15-р хороо,
Монголын үндэсний олимпийн хороо. 113 тоот.
Утас: 80081625, 72706020
И-майл: info@national-archery.mn

__2025.12.15___ № __01/0190__

Тодорхойлолт

Соёлын биет бус өв өвлөн уламжлагч, аймгийн мэргэн, спортын мастер Алтангэрэлийн Дагзмаа нь 1975 оноо Үндэсний сурын харваагаар хичээллэж, өв уламжлалын судалгаа хийх, сургалт явуулсаар ирсэн. Судалгааны үр дүнд үндэсний сурын харвааны 3 төрийн уухайг шинэчлэн тус бүтээлээр CD бичүүлж 450 хувь хэвлүүлэн олны хүртээл болгосон. Амжилтууд:

- Аймгийн баяр наадамд 17 удаа тэргүүн байр 5 удаа 2 дугаар байр, 1 удаа 5 дугаар байр,
- Улсын аварга шалгаруулах тэмцээнд 1, 2 дугаар байр,
- Ахмад харваачдын улсын аварга шалгаруулах тэмцээнд 1 дүгээр байр 1, 2, 3 дугаар байр тус бүр 2 удаа,
- Бусийн харвaанд 2, 3 дугаар байр тус бүр 2 удаа,
- Багийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 дугаар байр 2 удаа,
- Дүүрэг, сумын харвaанд 1, 2 дугаар байр тус бүр 13 удаа
- 2024 оны ахмадын оны шилдэг харваач
- Соёлын биет бус өв өвлөн уламжлагч 2018-2024 онуудад үндэсний сурын харваа, сурын харвааны уухай, уртын дуу, ерөөл магтаал, хэл хуурын үзүүлбэр, ёс заншлаар ард олондоо түгээн дэлгэрүүлж байна. Нүүдэлчин ардын соёлын өвийг хадгалах хамгаалах зэрэг олон ажил хийсэн.

Соёлын өвийг хамгаалахын зэрэгцээ үндэсний сурын харвааны 210 шавь бэлдсэн. Шавь нараас нь улсын наадмын түрүү 2, улсын Тод харваач 1, спортын мастер 37, дэд мастер 10, аймгийн цолтой 57. Үндэсний сураар хичээллэгч шавь нартаа соёлын өвөө өвлүүлэн үлдээсэн.

Олон улсын чуулганд 12 удаа оролцсон. Олон улсын харваанаас мөнгөн медаль хүртэж байсан. Нийт 11 улсад Монгол орноо сурталчлан, өв соёлоо түгээн дэлгэрүүлж ирсэн ахмад үеийн төлөөлөл юм.

ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С.АРИУНБАТ

**ASSOCIATION OF MONGOLIAN LONG SONG**
**МОНГОЛЫН УРТЫН ДУУНЫ ХОЛБОО**

20*25* оны *12* сарын *10* өдөр №*27* Улаанбаатар хот

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВД

Тодорхойлолт

Уртын дуучны өвлөн уламжлагч Алтангэрэл овогтой Дагзмаа (РЭ50110901) нь Монголын уртын дууны холбооны шилдэг өвлөн уламжлагчдын нэг болохыг үүгээр тодорхойлж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ЦЭРЭНДАГВА

УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛЫН УРТЫН ДУУНЫ ХОЛБОО НҮТББ
9023100536 1026569 ШЖР0980



**МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХ**
CITIZEN IDENTITY CARD OF MONGOLIA

**Овог** Family name
Бэйс
Beis

**Эцэг/эх/-ийн нэр** Surname
Алтангэрэл
Altangerel

**Нэр** Given name
ДАГЗМАА
DAGZMAA

**Хүйс** Sex
Эмэгтэй / Female

**Төрсөн он, сар, өдөр**
Date of birth
1951/11/09

**Регистрийн дугаар** Registration number
РЭ51110901 / RE51110901



**Олгосон байгууллага** Issuing authority
**Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар**
The General Authority for State Registration

**Олгосон он, сар, өдөр** Date of issue
2012/08/01

**Хүчинтэй хугацаа** Date of expiry
0000/00/00

**Хаяг** Address
УБ, Баянзүрх, 6-р хороо
13 хороолол, 21 байр
187 тоот

MNG

Баянзүрх дүүргийн 6 дугаар хорооны ахмад настан Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонт Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч, аймгийн мэргэн, спортын мастер Бэйс овогтой Алтангэрэлийн Дагзмаагийн ажил байдлын тодорхойлолт

Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 6 дугаар хорооны иргэн Хөвсгөл аймгийн уугуул, дээл боловсролтой. Мөрөн сумын 10 жилийн сургууль, Анагаах ухааны сургууль, намын дээд сургуулиудыг дүүргэсэн.1962 оноос одоог хүртэл урЛаг спортоор хичээллэн суралцаж нүүдэлчин ахуй, өвөг дээдэс ээж аавaacaa урдын дуу, халх сур харваа, уухай, хэл хуур, ерөөл магтаал, домын үлгэр өвлөн авч түгээн дэлгэрүүлж уламжлан 210-аад шавь бэлдсэн уран бүтээлч юм. Улсын баяр наадмын нээлтэд 47 удаа Улсын язгуур урлагийн наадамд тасралтгүй оролцож уран бүтээл толилуулан амжилттай яваа. Үүнд:

1996 онд язгуур урлагийн анхдугаар наадамд халх сур харвааны Уухай хэл хуурын ая, Хотгойдын найр эхэлдэг дуу "Өндөр сайхан бор" анх удаа улсын тайзан дээрээс олны хүртээл болгосон. Уг дууг Сомади багш жалханц хутагт Ц.Дамдинбазар гуай зохиож дуулсан дуу юм. 2006 онд Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн 800 уртын дууч, 800 морин хуурчдын тоглолтод амжилттай оролцсон. Дуулахаас гадна халх сур харвааны аймгийн мэргэн харваач спортын мастер. Улсын баярын харваанд 50 жил харваж уухайлж наадамчин олноо баясгаж байна. Үндэсний сурын холбооноос жил бүр зохион байгуулдаг 5-6 харвааны тэмцээнд 21 аймаг 300 гаруй сумдад хүрч харваа уухайг түгээн дэлгэрүүлж сургалт явуулдаг.

Бүтээлүүд:

2010 онд Шадар ван Чингүнжавын 300 жилийн ойд халх сур харвааны 3 төрлийн уухайгаар видео диск бүтээж 450 ширхэг өөрийн зардлаар хэвлүүлэн сургалтын зорилгоор үнэгүй тарааж түгээсэн.

Хотгойдын найрын дуу "Өндөр сайхан бор" дууг олны хүртээл болгосон.

Энэ 2 бүтээлээ Соёлын өвд бүртгүүлсэн. Гадаадын 11 улс оронд өөрийн хувийн зардлаар эх орноо, соёлын өвөө сурталчлан таниулсан.

2015 онд Нэгдсэн Үндэсний байгууллагын ивээл дор Бразил улсад нутгийн уугуул иргэдийн наадамд халх сур харваа, уухай уртын дуу Замба тивийн наран дуугаар

2016 онд Хятад улсын Нанчиво мужид дэлхийн 23 орны харваачидтай хүч сорьж халх харваа үндэсний хувцас, уухай уртын дуугаа танилцуулав.

2017 онд Төвдөд дэлхийн 23 орны харвааны наадамд амжилттай оролцсон.

2018 онд Унгар улсын Теглам хотод дэлхий харваа, тус улсын цэцгийн баярт ойрын зай, бартаат, хөдөлгөөнт харваанд амжилттай оролцсон.

2018 онд Япон улсын Токио хотод ээ хүү Чилүгэн, ээ охин Намуун болон 84 дүгээр сургуулийн сурагчидтай явж сургуультай шифийн холбоо тогтоож хүү Чилүгэн товх суранд сум гээлгүй онож Морин хуураар ая хуурдаж, Дагзмаа уртын дуу, уухай дуудаж өвөө түгээн талархал хүлээв.

2019 онд 6 сарын 23-30 -нд Өмнөд Солонгосын Сөүл хотод ээ охин Намуунтай МҮХАТ-ын шугамаар дэлхийн бүтээлч эмэгтэйчүүдийн чуулганд Монгол улсаа төлөөлөн халх сур харвааны 3 төрлийн уухайгаар мөнгөн медаль хүртэж уухай маань дэлхийн инновацын бүтээл болсон юм. Монгол уртын дуу Оломгүй далай дуугаар түмэн олны сонорыг мялааж талархал хүлээсэн.

2020 онд 2 сарын 8,9-нд АНУ-ын Вашингтон хотод охин Цэрэнхандын хамт дэлхийн монголч эрдэмтдийн хуралд "уухайгаар" илтгэл тавьж уухай дуудаж, уртын дуу Замба тивийн наран, Оломгүй далай, Дээлтэй цэнхэр, Будармаар будармаар салхи, Хотгойдын унага зэрэг дуу дуулж: ерөөл магтаал хэлсэн.

Дэлхийгээс хоёр мөнгөн медаль хүртсэн. ОХУ, Сингапур, Мексик, Испани, Голланд, Хятад баруун үзэмчин, Буриадад соёлын өвөө түгээн дэлгэрүүлсэн уламжилсан.

Олимпын сурталчилгаанд яамны мэргэжилтэн Бахетханаар ахлуулсан багт хамт явсан. Унгар улсад 10 сард Бөхийн дэлхийн аваргад Сумъяа аваргалсан.

Соёлын өв сурталчлан түгээн уламжлах ажилд гэр бүлээрээ хувийн зардлаар санаачилгатай ажиллаж байна.
2018 онд АНУ-д дэлхийн морин хуурын анхдугаар наадамд зээ хүү Чилүгэн, охин Цэрэнханд нарын хамт оролцож Чилүгэн хүү тэргүүн байрын шагнал хүртсэн.
Хөвсгөл аймгийн 24 сумаар өв соёлоо түгээн дэлгэрүүлж сургалт явуулж эрийн гурван наадмаар нааддаг болсон. Сур харвааны уухайг уртын дуу дуулж байна.
Нүүдэлчин наадамд 2018 оноос хойш 2025 оныг дуустал Мазаалай фестиваль өвлийн наадамд үндэсний музейтэй хамтран нүүдэлчин соёлын өвөө найр, сэвлэг үргээх, наадмын тухай ёс заншил дээж өргөх, цагаан сарын ёслол, ерөөл магтаал хүндлэх мэндлэх ёсны тухай сургалтаар иргэд олон нийтэд боловсрол олгож 3000 гаруй хүн хамрагдсан. Гадаадын зочид жуулчдад соёлын өвөө таниулж байна.
Өөрийн авьяас билгээ дайчлан шаргуу хөдөлмөрлөж улсаас шагнагдсан одон медаль:

1. Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон
2. Эхийн алдар одон-2
3. Эрүүлийг хамгаалах тэргүүний ажилтан, Соёлын тэргүүний ажилтан, БТТА 3 яамны шагнал
4. Ардын хувьсгалын ойн медаль 100, 90, 80, 70, 60 жил
5. Монголын Олимпын хорооны Олимпын алдар одон Алтан очир одон
6. МАХН-ын хүндэт тэмдэг
7. Тусгаар тогтнолын одон
8. Аймгийн мэргэн
9. Халх сурын болон Волейболын спортын мастер

МУГЖ Б.Батболдын үүсгэн байгуулсан Уртын дууны Өнө чуулгын уран бүтээлчээр, Бөхийн өргөөнд улс аймгийн алдар цолтой бөхийн барилдаан, ойн арга хэмжээ бүрэн тогтмол уртын дуу дуулж олны хүртээл болгож талархал хүлээж байна.
Улсад 37 жил үр бүтээлтэй эрүүл мэндийн салбарт хөдөлмөрлөсөн ахмад настан юм.
Халх сур харвааны шилдэг уухай, УАШТ алт мөнгөн медаль, АУШТ алт мөнгө хүртэл медальт оны шилдэг харваачаар шалгарсан.
Нийгмийн хариуцлагын хүрээнд: хандив тусламжид нэгдэх, хурал чуулганд идэвхтэй оролцсон. Корона вирус цар тахлын үед 2020 онд 2250 ширхэг маск гэр бүлээрээ оёж үнэгүй тараасан. Уртын дуу, Үндэсний сурын, Үндэсний спортын, БТС-ын холбоодын гишүүнд нэгдэж үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцож байна.
Түүний өв соёлоо дээдлэн хүндэтгэж, хойч үедээ өвлөн уламжилж, улс эх орноо гадна болон дотоодод сурталчлан түгээн дэлгэрүүлж байгаа их үйлсийг үнэлж Соёлын биет бус өвийг сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчийн шагналд тодорхойлж байна.

ТОДОРХОЙЛСОН:
ЗАСАГ ДАРГА Б.ЭНХБААТАР

СТС4468 9095489

## ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Ургийн овог: Бэйс

Овог нэр: Алтангэрэл

Нэр: Дагзмаа

Нас: 74

Хүйс: Эмэгтэй

Засаг захиргааны нэгж: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо, 64-р байр, 26 тоот

Өвийн төрөл зүйл: Сурын уухай, Сур харваа

Дагалдах өв: Уртын дуу, Ерөөл магтаал, Хэл хуур, Зүү эрхэж оёх, Уран бичлэг, уран хатгамал

Хэдэн жил өвлөсөн: 63 жил

**1. Товч танилцуулга:**

А.Дагзмаа нь1951 онд Хөвсгөл аймгийн Мөрөн хотод ууган охин болж мэндэлсэн. Одоо Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 6 дугаар хорооны иргэн, уламжлалт сурын уухай, сурын харвааг өвлөн уламжилсан.

А. Дагзмаа нь 12 настай буюу 4 дүгээр ангиасаа эхлэн буурай ээжийн ах Жамъян (Мундаг Жамъян гэлцдэг), буурал аав Х. Даваахүү (уртын дууч) эмэг эх Цэвэгийн Аюуш, аав Ганжууржавын Нямсүрэн нараар оньсого, харвах арга барил, 3 төрлөөр уянгалуулан дуудах уриа дуудлага, тойглох, гийнгоолох зэргийг заалган сурч өдийг хүртэл уламжилж, хөгжүүлж олон нийтэд түгээн дэлгэрүүлэж буй 4 дэх үеийн шилдэг өвлөн уламжлагч юм. Хөдөөд найр их болно. Найрт их авч явдаг, найраас Өндөр сайхан бор /Хотгойдын найрын дуу/, Эрдэнэ засгийн унага, Хулст нуур, Оломгүй далай гэх мэт дуунаас гадна төв халхын төрт ёсны дуунуудыг бүгдийг нь дуулдаг байсан. Тэр бүх дууг дуулж сурсан байдаг.

Буурай ээж Ц. Аюуш, ээж С. Магсаржав нарын тухайн үед шагнуулж байсан хуучны цаасан баримт, мөнгөн тэмдэг, судар зэрэг түүхийг нотлох баримтуудыг хадгалж авч үлдэж үр хойчдоо үлдээсэн байна.

Тэрээр 2001онд монгол сурын уухай, сурын харвааг хөгжүүлэх, түгээх зорилгоор "Хөвсгөл сурын харваа" холбоог үүсгэн байгуулж, 2003 онд Худалдаа аж үйлдвэрийн танхимд албан ёсоор бүртгүүлж сурын уухайг өвлүүлэн заах сургах, хамгаалах, хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг олон нийтэд зориулан зохион байгуулж ирснээс гадна сурын уухай, сур харвах уламжлалыг 300 гаруй хүнд өвлүүлсэн байна.

Сурын уухай уртын дуунаас улбаатай. Үндэсний сур харвааны судалгааг эхлүүлэн олон жил судалсан бөгөөд 1972 оноос суртай ойртож эхэлсэн байна. Энэ үеэс үндэсний сурын ахмад үе болох Анагаах ухааны профессор Балдандорж, Сэлэнгэ, Улаанбаатар хотын ахмад харваачдаас халх сурын уухайг нарийвчлан заалгасан. Уламжлалт гурван төрлийн уухай байдаг. Үүнд 1.Урилга, 2.Онооны 3.Самбарын уухай юм. Урилга уухай нь халх харваач сумаа нумуудаа онилонгуут сум

нь ирж  онохыг уриалж намуун дөлгөөн уриалж уухайлдаг. Онооны уухай нь сум нумаасаа гараад зурхайд ирж сур оносон үед хийдэг хөгжөөсөн, харваачаа урамшуулсан уухай байдаг. Самбарын уухай нь оноо тэмдэглээд сууж байгаа хүний ойр орчинд байгаа хүмүүс хийдэг уухай. Халх  харваачийн сум нь байнд онож сур оноход хийдэг уухай. Энэмэт гурван төрлийн уламжлалт уухайгаар 2010 онд Чингүнжавын 300 жилийн ойд зориулан цомог болгон 450 ширхгийг хэвлүүлж  олны хүртээл болгосон.

А. Дагзмаа нь 1976 оноос эхлэн Монгол улсын  21 аймаг, 320 гаруй сумын үндэсний баяр наадам бүрд оролцож сур харвахын зэрэгцээ уламжлалт өв соёлыг цаашид хөгжүүлэх, сонирхогчдын тоог нэмэгдүүлэх, харвааг  түгээн дэлгэрүүлэх зорилгоор сонирхогч,  хүүхэд залуучуудад сурын уухайн түүх, домог, харвааны уламжлалт уухай, харвах үеийн техник аргаас зааж сургасан. Бүх аймгаар явсан, очоогүй сумын тоо их цөөн. Суралцагч хүний тоо /шавь/ нийт 300 гаруй хүрсэн байна. Эзэмшсэн өвөө өвлүүлэх, сургах ажлыг танхимаар бус ахуй дээр нь голчлон  зааж сургасаар байна.

Мөн сурын уухай болон сур харвах гайхамшигийг дэлхийн дахинаа сурталичлан таниулах нийгмийн хариуцлагынхаа хүрээнд  АНУ, Түрк, Унгар, Мексик, Сингапур, БНСУ, Япон, ОХУ-ын Буриад улс, БНХАУ- ын ӨМӨЗО,Төвд, Бразил зэрэг орнуудад зардлаар томоохон үзэсгэлэн, соёлын арга хэмжээнүүдэд урилгаар өөрөө болон гэр бүлийн гишүүд болох үр хүүхэд, ач, зээ нарын хамтаар оролцохоос гадна уламжлалт сурын уухай болон харвааг таниулан сурталчиласаар байна. .

Түүний  гурван хуудас бүхий уухайн бүтээлнь 2019 онд БНСАУ-д зохион байгуулагдсан “Дэлхийн бүтээлч эмэгтэйчүүдийн чуулган-соёлын арга хэмжээ”-нд шалгарч “Олон улсын иновацын бүтээл”  төрөлд тэргүүлж мөнгөн медаль хүртжээ.

Мөн өөрийн эзэмшсэн дээрх уламжлалт уухайн технологи, арга барилын талаар соёлын биет бус өвийн баримтжуулалтад хамрагдан  Монгол Улсын Соёлын яамны харъяа Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын биет бус өвийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд архив болон хадгалуулжээ. Мөн ”2011 онд “Шилдэг уурхайч” -аар шалгарсан байна.

А. Дагзмааг 2018 онд “Нүүдэлчин наадам” -аас дэлхий дахинд уламжлалт өв соёлоо хамгийн олон оронд түгээн дэлгэрүүлж, сурталчилсан  хувь нэмрийг нь үнэлж тус наадмын шүүгчдийн нэрэмжит шагнал болох  “Батламж”-ыг гардуулж өгсөн байна.

Монголын үндэсний уран хатгамалчдын IV чуулган болон үндэсний хэмжээнд зохион байгуулагддаг улс болон бүсийн уралдаан тэмцээнүүдэд тогтмол идэвхи санаачлагтай оролцохын зэрэгцээ Монгол Улсаас уран хатгамалын өвийг ЮНЕСКО-д бүртгүүлэх санал санаачлагад нэгдэж  өөрийн хувь нэмрээ оруулсаар байна.

А. Дагзмаа нь Монгол Улсын засгийн газрын 2019 оны “Үндэсний жагсаалт батлах тухай” 475 дугаар тогтоолоор батлагдсан “Соёлын биет өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт”-д Уухай өвийн төрлөөр бүртгэгдсэн билээ.

**2. Соёлын биет бус өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр дотоод, гадаадад зохион байгуулагдсан  арга  хэмжээнд оролцсон болон  арга хэмжээ зохион байгуулсан байдал, гаргасан бүтээл:**

| д/д | Оролцсон томоохон арга хэмжээ | огноо | Дэлхийн болон үндэсний хэмжээнд |
|---|---|---|---|
| | **Сурын уухай- сурын харваа:** | | |
| 1 | 1978- 2025 он хүртэлх 47 удаагийн Үндэсний баяр наадмын сур харваанд оролцсон | 1962- 2025 | Үндэсний хэмжээнд |
| 2 | ОХУ-ын Буриад улсын Монгол Улсын хилийн уулзалт соёлын арга хэмжээнд оролцсон | 1981 | Олон улсын хэмжээнд |
| 3 | Монгол улсын Анхдугаар язгуур урлагийн наадмын шилдэгүүдийн тоглолт-Сурын харваа- уухайн үзүүлбэрээр | 1996 | Үндэсний хэмжээнд |
| 4 | “Хөвсгөл сурын холбоо” ТББ байгуулж сурын харвааг сурталчилсан | 2001 | |
| 5 | Халх сурын 3 төрлийн уухай бүтээлээр өөрийн бие даасан “Цомог” гаргаж Монгол Улсын оюуны өмчид бүртгүүлсэн. | 2010 | |
| 6 | БНХАУ-ын Төвдийн олон улсын харваачдын уралдаанд оролцсон | 2012 | Олон улсын хэмжээнд |
| 7 | БНХАУ-ын Нангино муж Дэлхийн олон улсын сур харваан наадамд оролцсон | 2016 | |
| 8 | Токио хотын шефийн холбоон арга хэмжээ- Үндэсний сур харваагаар харваж, уухайлж, уртын дуугаар оролцсон | 2016 | |
| 9 | ОХУ-ын Буриад улсын сур харваан арга хэмжээнд сурын уухайгаар оролцсон | 2017 | |
| 10 | ӨМӨЗО-ны баруун үзэмчин барга хошууны сурын харваа арга хэмжээнд сур харваагаар оролцсон | 2018 | |
| 11 | БНСАУ-ын Дэлхийн дэлхийн бүтээлч эмэгтэйчүүдийн чуулганд сурын уухайгаар дэлхийн иновацын төрөлд шалгарч мөнгөн медаль хүртсэн | 2019 | |
| 12 | “Нүүдэлчин Монгол” наадам-2018, 2019, 2022, 2025 онд“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд сурын уухай, сур харваа, уламжлалт ёс заншил, цагаан сар тэмдэглэх ёс, дом шившлэгээр оролцсон | 2018-2025 | Үндэсний хэмжээнд |
| 13 | “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд уламжлалт баяр наадам, уриа дуудлагаар оролцсон | 2023 | |
| | **Хэл хуур:** | | |
| 1 | Язгуур урлагийн наадмуудад 1996 оноос эхлэн тасралтгүй хэл хуур хөгжмийн төрлөөр оролцсон | 1996 | Үндэсний хэмжээнд |
| 2 | “Монгол угсаатны хэл хуурчдын холбооны анхдугаар чуулган- уралдаанд оролцсон | 2024 | |
| | **Уртын дуу:** | | |
| 1 | Жалханз хутагт Дамдинбазарын зохиол “Өндөр сайхан бор”дууг анх удаа дуулж олны хүртээл болгов. | 1999 | Үндэсний хэмжээнд |
| 2 | Бразили -Палмас хотын “Нутгийн уугуул иргэдийн наадам” -д Халх сурын харваан | 2015 | Олон улсын хэмжээнд |

| | | | |
|---|---|---|---|
| | уухай- МАУД “Уяхан замбуу тивийн нар” дуугаар оролцсон | | |
| 3 | Бөхийн нэрэмжит болон заалны барилдааны нээлтэд уртын дууны “Өнө” чуулгын уран бүтээлчийн хувьд уригдан оролцсон | 2020-2025 /Тогтмол/ | Үндэсний хэмжээнд |
| 4 | Үндэсний их баяр наадамд- уртын дуу, ерөөл магтаалаар | 2024 | |
| 5 | Архангай аймгийн “АРА” фестивалд уртын дуугаар оролцсон | 2025 | |
| 6 | Үндэсний их баяр наадмын нээлтийн арга хэмжээнд уртын дуучидтай хамт оролцсон | 1967, 1976-2025 хүртэл /тасралтгүй/ | |
| **Өөрийн бие даасан үзэсгэлэн:Уран бичлэг** | | | |
| 1 | “Эртний аялгуун дор сэрэхүй” Монгол зураг, уран бичлэгийн үзэсгэлэнд оролцсон | 2001 | Үндэсний хэмжээнд /Уран зургийн галарей/ |
| 2 | ”Амьд ертөнц” уран бичлэгийн үзэсгэлэнд оролцсон | 2007 | Үндэсний хэмжээнд /Дүрслэх урлагийн музей/ |
| 3 | “1-1=0” рок контемпорари үзэсгэлэнд оролцсон | 2011 | Үндэсний хэмжээнд /Уран зургийн галарей/ |
| 4 | “Монгол уран бичлэг”-ийг ЮНЕСКО-д бүртгүүлэхэд гар бие оролцсон | 2012-2013 | Дэлхийн хэмжээнд |
| **Хамтарсан уран бичлэг үзэсгэлэн:** | | | |
| 1 | “Эртний сайхан” үзэсгэлэнд оролцсон | 1997 | Үндэсний хэмжээнд /Уран зургийн галарей/ |
| 2 | “Ил товчоо” сонины нэрэмжит уран бичлэгийн улсын уралдаанд зориулсан үзэсгэлэнд оролцсон | 1997 | Үндэсний хэмжээнд /Залуу зохион бүтээгчдийн төв/ |
| 3 | “Монгол уран бичлэг” үзэсгэлэнд оролцсон | 1998 | Үндэсний хэмжээнд /Төв номын сан/ |
| 4 | “Билгийн цоморлиг” зураач Б. Хишигсүрэнгийн хамт оролцсон | 1998 | Үндэсний хэмжээнд /Уран зургийн галарей/ |
| 5 | “Бийрийн уран бичлэг” үзэсгэлэнд оролцсон | 1999 | Олон улсын хэмжээнд /ХБНГУ-ын Элчин сайдын яам/ |
| 6 | “Эртний сүр, өвгөдийн гэрээслэл” багш Жалайр До. Батбаярын хамт оролцсон | 2003 | Үндэсний хэмжээнд /Уран зургийн галарей/ |
| 7 | Чингис хаан монгол бичгийг төрийн бичиг | 2004 | Олон улсын |

| | | | |
|---|---|---|---|
| | болгосны 800 жилийн ойд зориулсан уран бүтээлчдийн хамтарсан үзэсгэлэд оролцсон | | хэмжээнд<br><br>/МУЭ- ийн үзэсгэлэнгийн танхим/ |
| **Уран хатгамал:** | | | |
| 1 | Монголын уран хатгамалчдын чуулган- Уран хатгамалчдын IV уралдад оролцсон | 2023 | Үндэсний музей |
| 2 | Уран хатгамалчдын улсын болон бүсийн уралдаан, тэмцээнд оролцсон | 2022- 2025 | Үндэсний хэмжээнд |

**3.Голлох гавьяа, шагнал:**

-Монгол Улсын "тэргүүний уран сайханч" тэмдэг 1976 он

- Халх сур харвааны "Аймгийн мэргэн" цол 1987он

-Эрүүлийг хамгаалах "Тэргүүний ажилтан" цол 2006 он

-"Алдарт эх"-ийн 2-р одон 2011 он

-Халх сур харвааны "Спортын мастер" цол 2011он

-Биеийн тамирын "Тэргүүний ажилтан" цол 2012он

- "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон" 2017он

-" Соёлын тэргүүний ажилтан" цол 2018он

-Үндэсний сурын улсын" шилдэг уухайч" 2018он

-Монгол Улсын Соёлын биет бус өвийг "Ур чадварын өндөр түвшинд өвлөн уламжлагч" 2019 он

СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ҮНДЭСНИЙ БОЛОН ДЭЛХИЙН ХЭМЖЭЭНД СУРТАЛЧЛАН АЛДАРШУУЛАХ, ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫГ ГЭРЧЛЭХ БАРИМТ БИЧИГ, ГЭРЭЛ ЗУРАГ, ДҮРС БИЧЛЭГ, БУСАД ЗҮЙЛ.

Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч, аймгийн мэргэн, спортын мастер Бэйс овогтой Алтангэрэлийн Дагзмаа миний бие нь 1951 оны 11 дүгээр сарын 09-ны Улаанбаатар хот Өргөө амаржих газарт мэндэлсэн. Хүүхэд байхаасаа соёлын биет бус өвийг өвөг дээдэс аав ээжээсээ уртын дуу, халх сур харваа, уухай, хэл хуур, ерөөл магтаал, домын үлгэр зэргийг өвлөн авч түгээн дэлгэрүүлж уламжлан 210 шавь бэлдсэн. 1975 оноос Үндэсний сурын харваагаар хичээллэж, өв уламжлалын судалгаа хийх, сургалт явуулсаар ирсэн.

Судалгааны үр дүнд үндэсний сурын харвааны 3 төрлийн уухайг шинэчлэн тус бүтээлээр CD бичүүлж 450 хувь хэвлүүлэн олны хүртээл болсон. Аймгийн баяр наадамд 17 удаа тэргүүн байр 5 удаа 2 дугаар байр, 1 удаа 5 дугаар байр, Улсын аварга шалгаруулах тэмцээнд 1,2 дугаар байр, Ахмад харваачдын улсын аварга шалгаруулах тэмцээнд 1 дүгээр байр 1,2,3 дугаар байр тус бүр 2 удаа, Бүсийн харвaанд 2,3 дугаар байр тус бүр 2 удаа, Багийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 дугаар байр 2 удаа, дүүрэг сумын харвaанд 1,2 дугаар байр тус бүр 13 удаа тус тус байр эзэлсэн.








2018-2024 онуудад үндэсний сурын харваа, сурын харвааны уухай, уртын дуу, ерөөл магтаал, хэл хуурын үзүүлбэр, ёс заншлаар ард олондоо түгээн дэлгэрүүлж байна. Нүүдэлчин ардын соёлын өвийг хадгалах хамгаалах зэрэг олон ажил хийсэн.

Соёлын өвийг хамгаалахын зэрэгцээ үндэсний сумын харвааны 210 шавь бэлдсэн. Шавь нараас нь улмын наадмын түрүү 2, улсын тод харваач 1, спортын мастер 37, дэд мастер 10, аймгийн цолтой 57. Үндэсний сураар хичээллэгч шавь нартаа соёлын өвөө өвлүүлэн үлдээсэн.







Олон улсын чуулганд 12 удаа оролцсон. Олон улсын харваанаас мөнгөн медаль хүртэж байсан. Нийт 11 улсад Монгол орноо сурталчлан өв соёлоо түгээн дэлгэрүүлж ирсэн.

2015 онд Нэгдсэн Үндэсний байгууллагын ивээл дор Бразил улсад нутгийн уугуул иргэдийн наадамд халх сур харваа, уухай уртын дуугаа танилцуулсан.

2016 онд Хятад улсын Нангигуа мужид дэлхийн 23 орны харваачидтай хүч сорьж халх харваа үндэсний хувцас, уухай уртын дуугаа танилцуулсан.

2017 онд Төвдөд дэлхийн 23 орны харвааны наадамд амжилттай оролцсон.

2018 онд  Унгар улсын Теглам хотод дэлхий харва, тус улсын цэцгийн баярт ойрын зай, бартаат, хөдөлгөөнт харвaанд амжилттай оролцсон.

2018 онд АНУ-д дэлхийн морин хуурын анхдугаар наадамд зээ хүү Чилүгэн, охин Цэрэнханд нарын хамт оролцож Чилүгэн хүү тэргүүн байрын шагнал хүртсэн

2018 онд Нүүдэлчин Монгол Соёлын биет бус өвийн их наадмын Соёлын биет бус өвийг олон улсад хамгийн их сурталчилж таниулсан өвлөн уламжлагч өргөмжлөл үнэ бүхий зүйлээр шагнуулж. Соёлын тэргүүний ажилтан болсон.

2019 онд Өмнөд Солонгосын Сөүл хотод зээ охин Намуунтай МҮХАТ-ын шугамаар дэлхийн бүтээлч эмэгтэйчүүдийн чуулганд Монгол улсаа төлөөлөн халх сур харвааны 3 төрлийн уухайгаар мөнгөн медаль хүртэж уухай маань дэлхийн инновацын бүтээл болсон.

2020 онд АНУ-ын Вашингтон хотод охин Цэрэнхандын хамт дэлхийн монголч эрдэмтдийн хуралд уухайгаар илтгэл тавьж уухай дуудаж, уртын дуу Замба тивийн наран, Оломгүй далай, Дээлтэй цэнхэн, Будармаар будармаар салхи, Хотгойдын унага зэрэг дуу дуулж, ерөөл магтаал хэлсэн.












2024 оны ахмадын оны шилдэг харваач

Олимпын сурталчилгаанд яамны мэргэжилтэн Бахетханаар ахлуулсан багт хамт явсан.

МУГЖ Б.Батболдын үүсгэн байгуулсан Уртын дууны Өнө чуулгын уран бүтээлчээр Бөхийн өргөөнд улс аймгийн алдар цолтой бөхийн барилдаан, ойн арга хэмжээ бүрэн тогтмол уртын дуу дуулж олны хүртээл болгож талархал хүлээж байна.

**Боловсрол:**

1959-1968 онд Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 10 жил
1968-1972 онд Анагаах ухааны сургууль
1985-1989 онд Намын дээд сургууль

**Хөдөлмөр эрхлэлт:**

1971-1975 онд Хөвсгөл аймгийн Түнэл сумын Хүн эмнэлгийн салбарын эрхлэгч
1975-1976 онд Хөвсгөл аймгийн Арбулаг сум Хүн эмнэлэгт эмч
1976-2000 онд Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэгт даргын туслах, боловсон хүчин, эмч
2000-2007 онд Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газрын Хог хаягдлын менежер

**Шагнал урамшуулал:**

- 2024 онд Зэв нүүлгэх харвааны эмэгтэй төрөлд 3 дугаар байр
- 2024 онд Ахмадын 2024 оны Улсын аварга шалгаруулах тэмцээнд тусгай байр
- 2024 онд 2024 оны харвaанд 4 дүгээр байр өргөмжлөл, мөнгөн шагнал
- 2024 онд Зэв нүүлгэх харвааны эмэгтэй төрөлд 3 дугаар байр
- 2023 онд өргөмжлөл
- 2023 онд Ахмадын аварга шалгаруулах уралдаанд 3 дугаар байр өргөмжлөл
- 2023 онд Шилдэг харваач
- 2023 онд Уран хатгамалчдын үндэсний IV уралдааны талархал
- 2022 оны Софт волейболын цуврал нээлттэй тэмцээний батламж
- 2022 онд 2022 оны улсын аварга шалгаруулах тэмцээний 3 дугаар байр, өргөмжлөл
- 2021 онд Алтан бөмбөгийн эзэн
- 2021 онд Алтан очир одон
- 2021 онд Отго харваа 5 дугаар байр
- 2019 онд Талархал
- 2019 онд Тусгаар тогтнол одон
- 2019 онд БЗД-ийн 6-р хорооны Засаг даргын өргөмжлөл
- 2018 онд Нүүдэлчин Монгол Соёлын биет бус өвийн их наадмын Соёлын биет бус өвийг олон улсад хамгийн их сурталчилж таниулсан өвлөн уламжлагч батламж
- 2018 онд Соёлын тэргүүний ажилтан
- 2018 онд Талархал
- 2017 онд Монголын ахмадын холбооны Хүндэт тэмдэг
- 2017 онд Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон
- 2016 онд Сурын харвааны эмэгтэй төрөлд 5 дугаар байр
- 2015 онд Олимпын хорооны Олимпын алдар одон
- 2013 онд БЗД-ийн Аварга шалгаруулах тэмцээн 3 дугаар байр, өргөмжлөл
- 2012 онд Үндэсний сурын эмэгтэй харваачдын багийн аварга шалгаруулах анхдугаар тэмцээнд 2 дугаар байр
- 2012 онд Талархал
- 2012 онд Багийн ажиллагаа хамтын манлайлал сэдэвт сургалтын гэрчилгээ
- 2012 онд Улсын аварга шалгаруулах тэмцээнд тусгай байр
- 2010 онд БЗД-ийн Аварга шалгаруулах тэмцээн дугаар байр, өргөмжлөл
- 2011 онд Ардын билэг урлагийн 5 дугаар байр
- 2011 онд 2011 оны ахмадын улсын аварга шалгаруулах тэмцээнд тэргүүн байр өргөмжлөл
- 2011 онд СХД-ийн аварга шалгаруулах тэмцээн тэргүүн байр
- 2011 онд Дэд байр
- 2011 онд Өргөмжлөл
- 2015 онд Эрийн гурван наамдын сурын харвааны дурсамж
- 2011 онд 2011 оны улсын аварга шалгаруулах тэмцээний 5 дугаар байр

- 2008 онд 2008 оны нээлтийн харвааnд 3 дугаар байр өргөмжлөл
- 2008 онд Улсын аварга шалгаруулах тэмцээн 3 дугаар байр
- 2007 онд Баянзүрх хайрхны тахилга 3 дугаар байр, өргөмжлөл
- 2006 онд Хөвсгөл аймгийн Үндэсний спортын III их наадмын аймгийн аварга шалгаруулах сурын харвааны тэргүүн байр, өргөмжлөл
- 2006 онд Эрүүлийг хамгаалах тэргүүний ажилтан
- 2006 онд Отог харвааны 3 дугаар байр
- Ардын хувьсгалын 60,70,80,90,100 жил
- 2006 онд Аймгийн мэргэн
- 2005 онд Хотгойдын дууны наадмын дурсамж
- 2005 онд Хөвсгөл аймгийн наадамд 3 дугаар байр, өргөмжлөл
- 2005 онд Туурайн төвөргөөн наадмын талархал
- 2003 онд Үндэсний их баяр наадмын тэргүүн байр, өргөмжлөл
- 2002 онд Жуух бичиг
- 2001 онд МУ-н тэргүүний ардын авьяастан дурсамж
- 2000 Харваачийн алдар
- 2000 онд Ардын хувьсгалын 79 жил, сурын харвааnд тэргүүн байр, өргөмжлөл
- Халх сурын болон волейболын спортын мастер
- 1989 онд Одон бөмбөгийн тэмцээний баярын бичиг
- 1989 онд шатрын тэмцээн баярын бичиг
- 1987 Дурсамж
- 1987 онд Баярын бичиг 3 удаа
- 1984 онд хөдөлмөрийн сахилга бат диплом
- 1983 онд Уран гартан уралдааны баярын бичиг
- 1983 онд Ард түмний социалист уралдааны Баярын бичиг
- 1982 Талархал
- 1982 Цасны баяр үйл ажиллагааны диплом
- 1982 онд Социалист түрүүлэгчдэд олгох дурсамж
- 1982 Урлагийн наадмын дурсамж
- 1978 онд Баярын бичиг
- 1970 Баярын бичиг
- 1971 Баярын бичиг гэх мэт бичигдээгүй Диплом 28, баярын бичиг 21, өргөмжлөл 5 сонингийн нийтлэл дээр гарсан 6 байна.

**Хавсралт материалууд:**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Дугаар 475 Улаанбаатар хот

ҮНДЭСНИЙ ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 13.1.8-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн "Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Дээрх жагсаалтад орсон өвлөн уламжлагчид батламж олгох, алдаршуулах, урамшуулах, шавь сургалт зохион байгуулахад нь дэмжлэг үзүүлэх зохих арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД У.ХҮРЭЛСҮХ

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД Ё.БААТАРБИЛЭГ

**Засгийн газрын 2019 оны 475 дугаар**

**тогтоолын хавсралт**

**СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧИЙН**

**ҮНДЭСНИЙ ЖАГСААЛТ**

| № | Билэг авьяастны нэр | Өвлөсөн өвийн төрөл | Төрсөн он | Үндсэн захиргаа (аймаг, сум, дүүрэг) |
|---|---|---|---|---|
| 1. Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд | | | | |
| 1. | Нямаагийн Анхбаяр | Тууль | 1974 | Увс аймгийн Наранбулаг сум |
| 2. | Эрдэнэцогтын Баатаржав | Тууль | 1972 | Ховд аймгийн Чандмань сум |
| 3. | Авирмэдийн Балдандорж | Урианхай тууль | 1978 | Ховд аймгийн Мөнххайрхан сум |
| 4. | Довдонгийн БАТБАЯР | Монгол уран бичлэг | 1959 | Улаанбаатар хот |
| 5. | Жаргалын Дагвасамба | Ерөөл | 1951 | Өмнөговь аймгийн Номгон сум |
| 6. | Нацагийн Дамдиндорж | Тууль, Цуурч, Хөөмийч | 1967 | Ховд аймгийн, Дуут сум |
| 7. | Сугирын Мөнхжаргал | Ерөөл | 1959 | Өмнөговь аймгийн Номгон сум |
| 8. | Гомбын Оргой | Ерөөл | 1935 | Өмнөговь аймгийн Мандал-Овоо сум |
| 9. | Дандарын Өлзий | Халх тууль | 1935 | Баянхонгор аймгийн Галуут сум |
| 10. | Дашдондогийн Цогзол | Үндэсний бөх цоллох | 1947 | Өвөрхангай аймгийн Бүрд сум |
| 11. | Цэенгийн Цэрэндорж | Магтаал | 1940 | Өмнөговь аймгийн Баян-Овоо сум |
| 2. Ардын язгуур урлаг | | | | |
| 1. | Готовын Арилд | Шагайн ухаай | 1947 | Дундговь аймгийн Дэрэн сум |
| 2. | Тайваны Арслан | Хотон бие биелгээ | 1953 | Увс аймгийн Тариалан сум |
| 3. | Пагамын Бааст | Захчин бие биелгээ | 1946 | Ховд аймгийн Булган сум |
| 4. | Өөдөсийн Базарбат | Ардын урт, богино дуу | 1952 | Өвөрхангай аймгийн Баянгол сум |
| 5. | Пүрэвдаваагийн Байгальжав | Ардын хөгжим урлал | 1958 | Өмнөговь аймгийн Цогт-Овоо сум |
| 6. | Лувсанцэрэнгийн Базарваань | Хөөмий | 1953 | Баянхонгор аймгийн Баянбулаг сум |
| 7. | Дурмагийн Балган | Хотон бие биелгээ | 1960 | Увс аймгийн Тариалан сум |
| 8. | Өлзийн Батжаргал | Монгол ардын уртын дууг хөгжимдөх уламжлалт арга барил-Лимбэний битүү амьсгаа | 1949 | Өмнөговь аймгийн Даланзадгад сум |
| 9. | Гэндэнгийн Баяртай | Дөрвөд бие биелгээ | 1956 | Увс аймгийн Улаангом сум |
| 10. | Долгорын Баттөмөр | Монгол ардын уртын дуу | 1949 | Өвөрхангай аймгийн Хужирт сум |
| 11. | Базарын Банзрагч | Морин хуур | 1949 | Баянхонгор аймгийн Бууцагаан сум |
| 12. | Цэрэнпилийн Буянхишиг | Торгууд бие биелгээ | 1951 | Ховд аймгийн Булган сум |
| 13. | Наранцогтын Буяндэлгэр | Урианхай цуур | 1967 | Баян-Өлгий аймгийн Буянт сум |
| 14. | Гүзээгийн Бүүвэйбаатар | Морин хуур | 1962 | Увс аймгийн Тариалан сум |
| 15. | Чойжинжавын Ваша | Лимбэний битүү амьсгаа | 1955 | Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум |
| 16. | Дашзэвгийн Галсантогтох | Монгол ардын уртын дууг хөгжимдөх уламжлалт арга барил-Лимбэний битүү амьсгаа | 1940 | Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сум |
| 17. | Балдангийн Даарьмаа | Ардын дуу | 1958 | Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сум |
| 18. | Рэнцэнгийн Даваажав | Хөөмий | 1952 | Ховд аймгийн Чандмань сум |
| 19. | Алтангэрэлийн Дагзмаа | Сурын харвааны "Ухай" | 1951 | Хөвсгөл аймгийн, Мөрөн сум |
| 20 | Гарамын Дадьсүрэн | Уртын дуу | 1942 | Дундговь аймгийн Дэрэн сум |
| 21. | Цэндийн Дондоо | Уртын дуу, Домог хууч яриа | 1930 | Булган аймгийн Дашинчилэн сум |
| 22. | Гомбын Дорждэрэм | Ардын богино дуу | 1929 | Булган аймгийн Бугат сум |
| 23. | Амаасүрэнгийн Доржпалам | Морин хуурын татлага | 1954 | Дундговь аймгийн Дэрэн сум |



Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалтын 19-д Сурын харвааны Ухай төрлөөр өвлөн уламжлагч болсон.

НҮҮДЭЛЧИН МОНГОЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

# Өргөмжлөл

ЭРХЭМ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧ А. Дагзмаа ТАНАА

"Нүүдэлчин Монгол" Соёлын биет бус өвийн их наадмын **"СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ОЛОН УЛСАД ХАМГИЙН ИХ СУРТАЛЧИЛЖ ТАНИУЛСАН ӨВЛӨН УЛАМЖЛАГЧ"** бөгөөд үндэсний өв соёлоо дэлхий дахинд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх үйлсэд оруулсан хувь нэмрийг тань өндрөөр үнэлж, Өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнав.

*Ард түмний соёлыг дээдлэгч*
*Эрхэм Танд баярлалаа*

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ИХ НААДМЫН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХОРООНЫ ДАРГА Г.ЭРДЭНЭБАТ

СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ИХ НААДМЫН ШҮҮГЧДИЙН
БҮРЭЛДЭХҮҮНИЙ АХЛАГЧ ...ЭНХБАТ

УЛААНБААТАР ХОТ
9104208 ХНТ1839
1118155933

УЛААНБААТАР ХОТ
2018 оны 08 дугаар сарын 12-ны өдөр

---

НҮҮДЭЛЧИН МОНГОЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

# БАТЛАМЖ

*Эрхэм хүндэт* А. Дагзмаа *Танаа*

*Ард түмний оюун сэтгэлгээний хосгүй үнэт зүйл болох Соёлын биет бус өвийг оюун ухаан, авьяас билэг, ур чадвараа дайчлан бүтээлчээр эзэмшиж, хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, хойч үедээ өвлүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан ТАНЫГ "Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч"- аар тодруулан БАТЛАМЖЛАВ.*

*Ард түмний соёлыг дээдлэгч*
*Эрхэм өвлөн уламжлагч Танд баярлалаа*

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ИХ НААДМЫН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХОРООНЫ ДАРГА Г.ЭРДЭНЭБАТ

Улаанбаатар хот
2018 он

# ТАЛАРХАЛ

Эрхэм хүндэт ......Дагзмаа...... Танаа

Монгол Улс Анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах Улсаа тунхагласны 94 жилийн ойн баярын өдрийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас Монголын уртын дууны холбоо, Монгол Улсын Консерваторын Дуулаачийн факультетийн Ж.Дорждагвын нэрэмжит танхим, Соёл Урлагийн Их Сургуулийн Н.Норовбанзадын нэрэмжит танхимтай хамтран зохион байгуулсан “Монгол төрийн айзам уртын дуу” 94 уртын дууч, 6 морин хуурч-100 уран бүтээлчийн хүндэтгэлийн ёслолд оролцсонд талархал илэрхийлье.

Таны өв соёлоо түгээн дэлгэрүүлэх эрхэм үйлс, цаашдын уран бүтээлд их амжилт хүсэн ерөөе.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА З.ЭНХБОЛД

2018 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр
Төрийн ордон, Улаанбаатар хот

# ХАРВАХ НЬ УХААН БОЛООД УРЛАГ ЮМ



Алунгоо ээжийн охид ухаантай ч төрнө, уран чиг төрнө. Мэргэн чиг төрнө. Нумын таван мөсийг хүүхдүүддээ хугалж ч нэг, хугалж эс болох ч нэг гүн ухааныг мэдрүүлсэн домог бий.

Тэгвэл Далай ээжийн нутгийн охин, сурын спортын мастер А.Дагзмааг Хөвсгөл нутаг биш улс танина. Спортын мастерын шавь нар ч өнөөдөр сайхан харваачид болон өсөж өндийсөөр буй нь сайн сайхан ерөөлийн дээд буй заа. Ач охин Ц.Сансармаа нь эмээгийнхээ эрдмийг өвлөн авч буй аж.

Ач охин Ц.Сансармаа: -Би эмээ шигээ гайхамшигийн эзэн болно гэж ярих аж. Ц.Сансармаа 2010 онд аймаг байгуулагдсаны 80, «Хотгойдын хурд-2» наадмын үндэсний сурын хүүхдийн харвааанд мөнгөн медаль хүртсэн амжилттай.

А.Дагзмаа үнэхээр том харваач. Тэрбээр өдгөө аймагтаа 13 удаа түрүүлжээ.

Шадар ван Чингүнжавын 300 жилийн ойд зориулж сур харвааны CD-гээ гаргасан харваач. 2014 онд халх сурын харвааны гурван төрлийн уухайг «Соёлын өв»-д бүртгүүлсэн гавьяатан бол А.Дагзмаа юм.

Их хутагтуудын шүтээн, тэдний зохиосон «Өндөр сайхан бор» дууг Монгол Улсын «Соёлын өв»-д бүртгүүлсэн хүн бол мөн л А.Дагзмаа. Энэ гайхамшигт дуугаар хотгойд түмэн найраа эхлүүлдэг ёсон эдүгээ ч хэвээр. Гавьяатны гавьяа эс хуучирна.

*А.Даваасамбуу*

2013 оны арванхоёрдугаар сарын 20. № 253 /1872/

# ...МГҮЙ ӨВ, СОЁЛОО ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД БҮРТГЭЛЖҮҮЛЛЭЭ

Н:
...тугай
...гүй



...ү ороох
...өвд өөрийн
...үүлнэ гэж

...лон биет бус
...өн тээгчдийг
...хай сонсоод
... Зүү ороох
...эм судрыг
... хэлтэл их
...ээн авсан.
... соёлын өвд
...лоо.

**...зүү ороох ...?**

... ангид
...а хөөрөгний
...дэг байсан.
... шинэ даалин
...жихдаа энэ
... дээ. Даалин
...ох оёдлоор
... хугацаа их
...р намар нь
...араас өмнө
...к дуусгадаг

**...глаа гээд
...иктэй урлал
...ын юмыг
...ж авав?**

... аа их
...хөдөлмөрч
...маань дээл
...г бол аав

